

БОРХЫН ГОЛЫН ЗАЛГАА ГУРВАН ХЭРЭМ

С. Бат-Эрдэнэ^{1,*}

Товч агуулга: Өгүүлэн буй хэрэм нь Завхан аймгийн Алдархаан сумын нутагт оршино. Тус хэрмийн талаар 1961 онд Х.Пэрлээ абугай “Монгол Ард Улсын эрт, дундад үеийн хот суурины товчоон” бүтээлдээ ерөнхий дурдсан байдаг бөгөөд тусгайлан судалсан зүйл хараахан үгүй одоог хүрсэн ажээ. Судлаач миний бие уг хэрмийн талаар 2020 онд очиж үзэн эхний ээлжийн баримтжуулалтыг хийж улмаар 2021, 2022, 2023 онуудад дахин судлаачдын хамт очин нарийвчилсан хайгуул судалгааг явуулж, агаарын зураглал, дэвсгэр зураг болон түүвэр судалгааг хийсэн болно. Дээрх хэрэм нь Манжийн үед холбогдох бөгөөд малтлага судалгаа явуулж нарийвчлан судалбаас хэрмийн доод талд эртний хуучин хот суурины турь байх бүрэн боломжтой юм.

Түлхүүр үг: Борхын гол, хэрэм, Манж, хүннүгийн язгууртны булш, жирийн булш

Удиртгал

Завхан аймаг нь Идэр, Богд, Чигэстэй, Завхан, Хүнгий, Тэс, Яруу голуудыг савлан Хангайн нурууны сүрлэг сайхан ой хөвчт уул нуруу, удам хөндий, тал хээр, элсэн манхан хосолсон нутаг билээ. Энэ нутагт олон мянган жилийн тэртээгээс хүн амьтан нутаглаж ирсэн ул мөр, түүх соёлын өв, дурсгалт зүйлүүд арвин бий. Богд, Чигэстэй, Завхан, Яруу, Хүнгий голын сав дагуу эрт галавын үлэг гүрвэл зэрэг амьтдын яснаас эхлүүлээд балар эртний хүний амьдарч байсан ул мөр болох чулуун зэвсгийн бууц, хадны зураг, булш бунхан, хот суурины туриуд элбэг.

Өгүүлэн буй хэрэм нь Завхан аймгийн Алдархаан сумын нутагт орших бөгөөд тус сумын нутагт түүхийн олон үеийн овог аймаг, улс үндэстэн нутаглаж, улс төрийн амьдрал өрнөн оргилж байсны маргашгүй ул мөр болох хот, балгас, хэрэм цайзын үлдэгдэл ч олон байна. Тухайлбал, Борхын голын хэрэм (Өгөөмөрийн хэрэм), Хар хясааны хэрэм, Повронгийн баруун хойд цайзын турь, Донойн хөндийн хэрэм, Яруу голын Алдар толгойн хэрмийн үлдэгдэл зэргийг дурдаж болно (Ёндон нар 2020: 13-14).

Уг газарт 1730-аад оны эхээр Баруун Монгол буюу Зүүн гарыг байлдан эзлэх Манжийн их цэргийн нэг хэсэг нь Цагаан сүүл гэдэг газар төвлөрөн сууж байсан бөгөөд үүнийг “Цагаан сүүлийн цэргийн хүрээ” гэж нэрийдэж байжээ. Энэхүү Цагаан сүүл гэдэг нь Өгөөмөр багийн төвийн хойд талд орших өвөр энгэртээ ихэр хоёр бууцтай жижиг цагаан толгойг нэрлэх аж. Манжийн Халхад суулгасан цэрэг тэр бүр хамгаалах, дайтах үүргээ биелүүлэх газар нутгийг

зөв олж байрлаж чадаагүйгээс анхны байрлуулсан газраа өөрчилж байжээ. Манж нар Цагаан сүүлийн цэргийн нэг хэсгийг нүүлгэн одоогийн Алдархаан сумын Алдар толгойн тус газар ирүүлжээ. Цагаан сүүлд сууж байсан их цэргийн хэсгийг нүүлгэсний учрыг тайлбарлан манж жанжин бичихдээ “Цагаан сүүл гэгч алтайн хэд хэдэн замыг хүлээсэн чухал газар тул хот үйлдэж цэргийг хэд хэдэн жил суулгасан бөлгөө. Түлэх мод, бэлчээр хүрэхгүй учир тийнхүү Алдар толгойд нүүлгэв” (Ёндон нар 2020: 173) хэмээн тэмдэглэжээ. Энэ тухай манжийн Найралт төв хааны 11 дүгээр оны (1733 оны) хавар жанжин Шибү эзэн хаандаа өргөсөн айлтгалдаа Алдар толгойд суулгасан цэргийг “Хожим түлэх мод, бэлчээр хүрэлцэхгүй учир ноднин жил... Улиастайн газарт нүүлгэн суулгажээ. Хулгай ойр халдан ирж чадахгүйн тулд Улиастайн газарт дотоод гадаадад мод босгож, дунд нь хөрс шороо дагтаршуулан хот үйлдэж, хотын дотор санхүү байгуулж эсэргүүн жил ногоо гарсныг үзэж албаны тэмээг авчирч Цагаан сүүлд хадгалсан цалин будаа, цэргийн зэвсэг, дарийн зэрэг юмсыг дараа дараагаар зөөн авчирсугай” гэжээ”. Манжийн хаан энэхүү айлтгалыг цэргийн тухайн хэргийг шийтгэгч сайдуудаар хэлэлцүүлээд 1733 оны зун билгийн улирлын 4 дүгээр сарын цагаан бичин өдөр цөм гуйсан ёсоор болгосугай гэсэн зарлиг буулгажээ (Ёндон нар 2020: 174).

Хожим Засагт хан аймгийн чуулганыг Заг голын эх Биндэрьяа нуурын чуулган гэж газар усны нэрээр нэрлэх болжээ. Энэ нь одоогийн Яруу, Алдархаан сумын Яруугийн голыг Заг гол, Яруу сумын Хаг нуурыг Биндэрьяа нуур гэх болсон ажээ. Үүний дараагаар аймгийн хурлыг Алдархаан сумын Алдар бригадын нутаг, Яруугийн голын Цагаан эрэг гэдэг газар төвлөрүүлэхээр тогтоожээ. Үүнээс хойш

¹ ШУТИС, Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль

* Холбоо барих зохиогч: bat-erdene.s@must.edu.mn

аймгийн яам нэг нутгаас нөгөөд нүүдэллэж 1924 оны 11 дүгээр сард одоогийн Алдархаан сумын нутаг Борхын Өгөөмөрт суурьшиж байв (Ёндон нар 2020: 37) гэсэн мэдээ бий.

Дурдан буй энэхүү дурсгал нь Өгөөмөр багийн нутагт орших ба миний бие анх 2020 онд очиж бүртгэн тэмдэглээд, агаарын зураглалыг хийж, түүний дараа 2022 онд доктор Ю.Болдбаатар, доктор С.Өлзийбаяр нарын хамт, мөн тус одоо доктор Ц.Бямба-Очир, доктор, профессор Н.Галиймаа, ОХУ-ийн эрдэмтэн доктор, профессор А.С.Панарин нарын хамт дахин очиж хэмжилт судалгааг хийж, агаарын төлөвлөгөөт нислэгийн үйлдэн “Metashape” ашиглан боловсруулалт хийсэн болно (Зураг 1, 2).

Хэрмийн тодорхойлолт

Уг хэрэм нь Завхан аймгийн төв Улиастай хотоос 75 км, Алдархаан сумын төвөөс баруун урагш 30 гаруй км зайд хойд өргөргийн 47°29'39.72”, зүүн уртрагийн 96°11'41.53” хэмд, Борхын голын хойд эргийн тохойрсон хошуун дээр оршино. Уг газарт хожим социализмын үед Өгөөмөрийн бригад байрлаж байсан ба газарзүйн байрлалын хувьд зүүн урд талд нь Борхын гол, Их Монгол элсний зүүн үзүүр, баруун талд нь Өгөөмөр уул, Бор хайрхан, Улаан хайрхан, хойд талд нь хангай нуруу өндөр хадтай уулс болох Халзан бүргэдтэй, Хөшиг, Эх ямаан ус, Тэхийн зогсоол, Баруун, Зүүн хайрхан зэрэг оршино.

Уг хэрэм нь голын эрэг дээр тэгш өндөрлөг хэсэгт байрлах ба зүүн хойноос баруун урд чиглэлтэй 3 хэрмээс бүтнэ. Шороог дагтаршуулан үйлдсэн тэг дөрвөлжин хэрэмтэй, хэрмийн гадуур эрт цагт, анх байгуулахдаа суваг шуудуу ухаж, түүнээс гарсан шороогоор хэрмийг дэлдсэн болов уу гэмээр байна.

Зүүн хэрэм: Давхар хэрэмтэй, гадна хэрэм 600х600 м хэмжээтэй, далангийн өргөн 9 м орчим, өндөр 1м орчим, шуудуун өргөн 2 м байна. Гадна хэрэм урд талдаа далангүй. Дотор хэрэм нь 460х460 м хэмжээтэй, далангийн өргөн 10 м, өндөр 60-100 см, шуудуун өргөн 6м, гадна дотор хэрмийн хоорондын зай 40м зайтай. Хэрэм гадна талаараа суваг, шороон далантай байжээ. Гадна хэрэм дотор хэрмийг бодвол далан нь илүү нарийн 5м өргөнтэй, гадуураа ус зайлуулах шуудуу, сувагтай ажээ. Хэрмийн баруун болон зүүн талд 2 хаалга, урд, хойд талд тус бүр 1 хаалга мэдэгдэж байна. Гадна хэрмийн урд талыг Борхын голын эрэгт тулган барьсан бөгөөд давхар далан үгүй. Зүүн урд хэсгээрээ Борхын голын усанд идэгдэж хэрмийн үзүүр нурсан байдалтай. Хэрмийн дотор талд өмнө нь ямар нэгэн барилга байгууламж байсан ул мөр байна. Зүүн хойд талд нь 180х210 м хэмжээтэй томоохон барилга байсан турь мэдэгдэх бөгөөд хуучны Өгөөмөр багийн үлдэгдэл бололтой. Түүний баруун талд цувраа олон

турь байх ба ямар зориулалттай нь тодорхойгүй аж. Мөн хэрмэн дотор шил хайлуулж хийж байсан ул мөр болох шилний цутгамал баас, шилний хагархайнууд нэлээдгүй тоогоор олдож байна. Түүнчлэн Манжийн үед холбогдох цэнхэр шаазан, бор болон хар лакан шаазангийн үлдэгдэл цөөнгүй илэрч байна. Хэрмийн дотор талд хэсэг газарт 1-3м голч бүхий дугуй нүхнүүдийн үлдэгдэл байх бөгөөд ямар нэгэн үйлдвэрлэл эрхэлж байсан ул мөр бололтой.

Голын хэрэм: Голын хэрэм нь зүүн хэрмийг бодвол харьцангуй жижиг хэмжээтэй. Борхын голын 3 хэрмээс баруун талын 2 хэрэм зүүн талын хэрмээ бодвол харьцангуй жижиг бөгөөд хоорондоо ойролцоо хэмжээтэй болно. Голын хэрэм нь зүүн, баруун хэрэмтэй шууд залгах бөгөөд зүүн хэрэмтэй адил давхар шороон далантай ажээ. Гадна талын шороон далан 183х160 м хэмжээтэй, далангийн өргөн 9 м орчим, шуудуун өргөн 2,5 м хэмжээтэй байна. Дотор талын шороон далангийн хэмжээ 137х126 м хэмжээтэй, өргөн 4 м орчим, шуудуун өргөн 1,2 м хэмжээтэй байна. Хэрмийн баруун хойд хэсэгт, мөн урд хэсэгт хаалга байсан бололтой бүдэг ул мөр мэдэгдэж байна. Зүүн хэрмийн адил шавар ваарны хагархай, төмөр эдлэл, цэнхэр шаазангийн хагархай мөн илэрч байна.

Баруун хэрэм: Баруун хэрэм нь хэмжээний хувьд голын хэрэмтэй ойролцоо 198х184 м хэмжээтэй, хэрмийн өргөн 4,5 м орчим, шуудуу мэдэгдэхгүй байна. Зүүн болон голын хэрмийг бодвол давхар шороон далангүй дан хэрэм болно. Уг хэрэм нь зүүн болон голын хэрмээс сүүлд баригдсан бололтой. Учир нь баруун хэрмийн зүүн хойд талын булан голын хэрмийн баруун урд талын доторх шороон далантай залгах бөгөөд харьцангуй өндөр далантай ажээ. Өөрөөр хэлбэл голын хэрмийг барьсны дараа дотор талын шороон даланг баруун хэрмийн зүүн хойд тал болгон ашигласан нь тодорхой харагдаж байна.

Олдвор хэрэглэгдэхүүн

Уг хэрмүүдийн дотор талаас Манжийн үеийн цэнхэр шаазангийн хагархай олон тоогоор олдоно (Зураг 3). Энэ төрлийн шаазангууд Юань улсын үеэс улбаатай бөгөөд Хятадын Жан Си мужийн Жин Дэ Жин дэх шаазангийн үйлдвэр нь Юань улсын үеэс алдаршиж Мин, Чин улсын үед үйлдвэрлэлээ тасралтгүй явуулж ирсний гадна одоо ч ажилласаар байдаг. Жин Дэ Жин үйлдвэрт Юань улсын үед хийгдсэн хөх цэнхэр хээтэй шаазан ихэд алдаршиж Иран, Турк, гэх мэт исламын шүтлэгт орнуудаас ирсэн захиалгаар хийсэн байх гэж үзэх явдал бий. Ийм бараан цэнхэр өнгийг Исламын шашинд Мухаммедын өнгө гэж хүндэтгэн үздэг. Монгол нутгаас Жин Дэ Жин хийцийн цэнхэр луун хээтэй цагаан шаазан

таваг, цэнхэр шувуу, цэцгэн хээтэй цагаан таваг, Монголын эртний нийслэл Хархорум хотын турias олдсон нь Монголын үндэсний музей, ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн сан хөмрөгт хадгалагдаж байна (Батсайхан, Төрбат 2013: 8). Тиймээс дээрх цэнхэр шаазан нь Манжийн үед уламжлагдан ирж, ихээр хэрэглэгдэж байсан нь түүвэр олдворуудаар илэрсэн шаазангуудыг хагархай гэрчилж байна. Мөн Манжийн үеийн шар шавран ваарны хагархай (Зураг 4), хар лакан гадаргуутай ваарны хагархай, улаан хүрэн ваарны хагархай элбэг тохиолдоно (Зураг 5). Түүнчлэн шил хайлуулж хийж байсан бололтой хайлсан шилний цутгамал баас, шилний хагархай нэлээдгүй илэрч байна (Зураг 6). Социализмын үед Өгөөмөр баг уг хэрмэн дээр байрлаж байсан бөгөөд зүүн хэрмийн дотор талд одоо ч хуучны байшингийн тууриуд бий. Тиймээс социализмын үед Их Монголын элсний түүхий эдийг ашиглан шил үйлдвэрлэж байсан эсхүл түүнээс эрт шил үйлдвэрлэж байсан бололтой. Төмөр эдлэл хэрэглэгдэхүүний хувьд төмрийн баас, хадаас, гархи (Зураг 7) зэрэг олдож байгаа нь харьцангуй хожуу үед холбогдох ажээ.

Товч дүгнэлт

Энэхүү өгүүллийн хүрээнд өмнө нь тойм төдий дурдагдсан уг хэрмийн талаар тодорхойлолт үйлдэн агаарын зураглалыг хийж цаашдын судлаачдад судалгааны хэрэглэгдэхүүн буй болгох гэж зорилоо.

XVIII зууны эхнээс XIX зууны дундуур хүртэл Манж нар Халх Монголд цэргийн хот, тариалангийн суурин олон байгуулсан нь бичгийн сурвалж ба археологийн баримтаар мэдэгдэж байна. Манжийн цэргийн ангиуд "...газар бүр хот дагтаршин үйлдэж, хэрэв хэрэг буй бөгөөс орж хамгаалуулсугай" гэсэн тушаалыг ягштал гүйцэтгэж байжээ (Пэрлээ 1961: 139). Тиймээс ч Манжийн үеийн цэргийн бэхлэлт, хот суурин, өртөөнүүд нь өнөөгийн Алтай нурууны зүүн хойд талаас эхлэн Хангай нурууг дамнан өргөргийн дагуу өртөөлөн байгуулсан нь сүүлийн үед хийгдэж буй археологийн хайгуул судалгаагаар мэдэгдэх болжээ.

Уг залгаа гурван хэрмийн хэмжээ, гүймэг хайгуулын явцад илрүүлсэн түүвэр олдворуудаас ажиглахад тодорхой хугацаанд нэлээд олон хүн ам суурьшиж байсан бололтой. Эдгээрээс хамгийн том нь зүүн хэрэм бөгөөд түрүүлж байгуулагдсан байх боломжтой нь шороон далангаас харагдаж байна. Харин голын болон баруун хэрэм нь харьцангуй жижиг бөгөөд баригдсан дарааллын хувьд зүүнээс баруун тийш чиглэлтэй байгуулжээ хэмээн таамаглаж болохоор байна. Өөрөөр хэлбэл шороон далангийн байдлаас зүүн талын хэрмийн баруун урд шороон далан дээр давхарлан голын хэрмийн даланг, голын

хэрмийн зүүн урд шороон далан дээр баруун хэрмийн шороон даланг байгуулсан нь агаарын зураглалаас мэдэгдэнэ.

Эцэст нь, Борхын голын цувраа гурван хэрмийг урьдчилсан байдлаар Манжийн үед буюу XVIII зууны эхэн хагаст холбогдуулан авч үзэх боломжтой хэдий ч түүний эргэн тойронд, Өгөөмөр ууланд 130, Ямаан усанд 150, Хүүшийн өвөлжөөнд 90, Бүрэн хайрханд 70 тооны хүннүгийн язгууртны болон жирийн булшнууд бүхий оршуулгын газрууд байгаа нь магадгүй хэрмийн ойр орчимд тухайн үеийн бууц суурин илрэхийг үгүйсгэх аргагүй юм.

Abstract

REMAINS OF THREE ANCIENT CITIES IN A ROW NEAR BORKH RIVER

by Sukhbaatar Bat-Erdene

The wall is located in Aldarkhaan sum of Zavkhan province. In 1961, Kh.Perley made a general mention of the wall in his work "Early and muddle period urban settlements of the People's republic of Mongolia", and it has not been specifically studied until now. As a researcher, I visited the wall in 2020 and did the first round of documentation, and then 2021, 2022 and 2023, I went back with researchers to make detailed survey, aerograph, background photos and sample survey. The above wall is related to the Manchurian period and it's quite possible that there are ruins of an ancient city at the bottom of the wall after conducting detailed excavation research.

Keywords: Borkh river, walled site, Manchuria, Xiongnu aristocratic tomb, burial of commoner

Ном зүй

Батсайхан Ц., Төрбат Н. (2013). Монгол шаазан. УБ.


Ёндон Д., Лодойсамбуу Д., Сүхгэрэл Д., Дармаа Б., Чойжилсүрэн Б., Баатар Н. (2020). Завхан аймгийн түүхэн тойм. УБ.

Пэрлээ Х. (1961). Монгол Ард Улсын эрт, дундад үеийн хот суурины товчоон. УБ.






Зураг 1. Агаарын ерөнхий зураглал



Зураг 2. Гурван хэрмийн дэвсгэр зураг




Зураг 3. Манжийн үеийн цэнхэр шаазангийн хагархай




Зураг 4. Шар шавран ваарны хагархай



Зураг 5. Хар наалантай шавар ваарны хагархай



Зураг 6. Шил хайлуулж байсан ул мөр болох шилний баас



Зураг 7. Төмөр эдлэл, хадаас